



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 07/48

Булган

Газар ашигласны төлбөр, хог хаягдлын  
хураамж авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 52 дугаар зүйлийн 52.1.2, 52.1.4, 52.1.12, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2.1, 9.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын нэгдсэн ноолуурын тушаалтын үеэр задгай талбайд худалдаа эрхэлж буй иргэн болон 1-5 тоннын автомашинд 2 өдрийн 30000 (гучин мянган) төгрөгөөр, 5 тонноос дээш автомашинд 2 өдрийн 40000 (дөчин мянган) төгрөгөөр тогтоосугай.
2. Батлагдсан тогтоолыг мөрдөж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Идэрмөнх)-д үүрэг болгосугай.
3. Ноолуурын нэгдсэн тушаалтын үеэр нийгмийн дэг журам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллахыг хэсгийн төлөөлөгч, дэслэгч (Б.Батсайхан)-д үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Э.Бүжмаа)-д даалгасугай.

ДАРГА *Б.Идэрмөнх* Ж.ДОЛООН-ОД



0721027

D:\Togtool\togtool 2022.docx